

БАТЛАВ:
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
 Ц.ЧОГСОМЖАВ

2023 ОНЫ ХЭНТИЙ АЙМГИЙН
 АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв (Орон нутаг)	Хариуцах эзэн	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
1	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тус газраас авч АЗДТГ, АИТХ, СЗДТГ-ын цахим хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube сувар), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллах.</p>	0	<p>АЗДТГ-ын мэргэжилтэн С.Оюун-Эрдэнэ Т.Бямбадулам</p>	<p>-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.</p>
		<p>1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах; Үүнд: -Шударга ёсны танхимын гишүүд багш нартай хамтарч төрийн байгууллагуудад соён гэгээрүүлэх нөлөөллийн фокус ярилцлагууд зохион байгуулах -Авлигын эсрэг өдрийг угтан тусгай хөтөлбөрөөр аймгийн хэмжээнд өдөрлөг зохион байгуулах</p>	1 сая	<p>ЭБАТ-ны баг Шударга ёсны танхимын багш нар</p>	<p>-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.</p>

		-Байгууллагын дарга нарт авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг би болгох арга хэмжээ зохион байгуулах.			
		1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг 22 агентлаг, 18 сумын Засаг даргын Тамгын газарт ажиллуулах;	0	АЗДТГ-ын мэргэжилтэн Ш.Эрдэнэжаргал Т.Бямбадулам	-Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.
		1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошюр зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийх видео уралдаан зарлаж бүтээлүүдийг олон нийтэд хүргэсэн байх.	2 сая	ЭБАТ-ны баг Д.Уламбаяр П.Ариунбаатар	-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх.
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	2.1.Аймгийн хэмжээнд Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг хагас бүтэн жилээр 2 хувааж авлигын эсрэг сургалтад АТГ-тай хамтран хамруулсан байх;	1 сая	ЭБАТ-ны баг Ц.Туяасайхан АЗДТГ-ын мэргэжилтэн Ш.Эрдэнэжаргал Т.Бямбадулам	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
		2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг байгууллагын судалгаа гаргаж (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран	0	ЭБАТ-ны баг	-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.

		ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) тухайн байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.			
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	0	АЗДТГ-ын мэргэжилтэн Ц.Бат-Эрдэнэ С.Мягмарбаатар	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
		3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	0	ЭБАТ-ны баг Н.Үнэнбат	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.
4	Авлига, ашиг сонирхлын	4.1. Аймгийн Засаг даргаас олгодог 4 төрлийн тусгай зөвшөөрлийг сунгах,	0	Ж.Гантулга	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан

	зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	шинээр олгох харилцааг болон орон нутгийн 8 байгууллагын 72 цахим үйлчилгээг иргэн аж ахуй нэгж байгууллага цахимаар авч хэвших үйл ажиллагааг сурталчлах хэвшүүлэх. Мөн төрийн албан хаагчийг үнэлэх үнэлгээний төхөөрөмж, үнэлгээний хорооны хурлын болон барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын хуралдааны бичлэгүүдэд тавих хяналтыг сайжруулж олон нийтэд сурталчлах арга хэмжээ авах. (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/			сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх;
		4.2.Аймгийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах, шалтгаан нөхцөлийг тогтоож арилгах арга хэмжээг эхлүүлэх мөн эрсдэлтэй албан хаагчийн судалгааг гаргаж сургалт зохион байгуулах	500000	ЭБАТ-ны баг	-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх
		4.3.Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	500000		-Бодитой үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл,	5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр	0	Ж.Гантулга	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;

	санаачилга өрнүүлэх	дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;			-Арга хэмжээнд удирдлагын -Тайланд нотломжийг хавсаргасан байх.
		5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд тухай бүр санал өгөх		Ж.Гантулга	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.

...oOo...